



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 26/09

Улаанбаатар хот

Төрийн шагналд уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улс, нийслэл, дүүрэг, орон нутгийн хөгжил, цэцэглэлтэд үнэтэй хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа олон жил үр бүтээлтэй ажилласан иргэдийг төрийн шагналд уламжилсугай.

2. Төрийн шагналд уламжлах иргэдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Шагналд уламжилсан иргэдийн материалыг зохих журмын дагуу бүрдүүлж холбогдох газарт уламжлахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (М.Давааням)-нд даалгасугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

1226010030